



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

2018 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 10/794

Улаанбаатар хот

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР-Т

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Налайх дүүргийн 7 дугаар хороо
2. Зургийн шифр, зураг төслийн компани: ЗТК-03/2018 “Зураг төсөл консалтинг” ХХК.
3. Архитектур төлөвлөлтийн даалгавар: Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын 2017 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн МЗХ2017/23-29 дугаартай.
4. Барилга байгууламжийн зориулалт: Нутгийн захиргааны ордны барилга
5. Барилгын давхар, талбай, эзэлхүүн: 2 давхар, $V = 8084,75\text{м}^3$,
6. Галд тэсвэршилтын зэрэг: төлөвлөсөн: II
7. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф3, Ф4
8. Зургийн иж бүрдэл 5 хэсэг.

Хоёр. Дүгнэлт

Монгол Улс төрийн байгууллагын газар эзэмших эрхийн “Гэрчилгээ” №000439296 Налайх дүүргийн Засаг даргын тамгын газарт Улаанбаатар хот Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Засаг даргын 2017 оны 09 дугаар сарын 04-ний өдрийн А/657 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 18668296350357 дугаар бүхий 67870 м² /га/ газрыг 15 жилийн хугацаатай Налайх дүүргийн 7 дугаар хороо нутгийн захиргааны ордны зориулалтаар баригдах барилгын ажлын зурагт хяналт хийхэд:

1. Гал тэсвэршилтийн I-III зэрэглэлийн барилгын гадна ханын гадаргууг шатдаг, тэсвэрлэн шатдаг материалаар өнгөлөхийг зөвшөөрөхгүй. /БНБД 21-01-02/-ийн 2.8, Барилгын гадна ханын дулаалгад галд шатдаггүй материал сонгож төлөвлөх /материалын шинжилгээний дүгнэлтийг хавсаргах/
2. Барилга баригдах байршилд барилга хоорондын гал эсэргүүцэх зай хэмжээг /БНБД 30-01-04/-ийн заавал мөрдөх 4 дүгээр хавсралтын дагуу хийж гүйцэтгэх.
3. Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах /MNS5566:2005/ стандартын дагуу үйлчилгээ явуулдаг өрөө тасалгаанд гал унтраагуул байрлуулж, галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, аврах гарцын тэмдэг тэмдэглэгээ бичиж байрлуулах.

